

Мэдээллийн нууцлалын тухай

1. Юуны тухай вэ?

Энэхүү мэдээллийн нууцлал нь „ВАДЕМИКУМ-Хөгжлийн хөтөч“, ялангуяа www.vademecum-digital.ch вебсайт, аппликейшн болон ВАДЕМИКУМ-дижитал хувилбарын домайнд хамаарна.

Таны хувийн нууцыг хамгаалах нь бидний хувьд чухал. Бид таны хувийн байдал, хувийн нууцыг хүндэтгэн хамгаалж, таны хувийн мэдээллийг хууль ёсны дагуу боловсруулна. Хууль эрх зүйн үндэс нь Швейцарийн Холбооны Улсын мэдээллийн нууцыг хамгаалах тухай хууль болон холбогдох журмууд юм. Үүнээс гадна бид мэдээллийн нууцыг хамгаалах талаарх Европын дүрэм журмыг дагаж мөрддөг. Мэдээллийг хамгаалах тухай хуулийн зорилго нь таны тухай мэдээллийг боловсруулахтай холбоотойгоор таны хувийн байдлыг хамгаалах явдал юм.

Хувийн мэдээлэл гэдэг нь тодорхой эсвэл таних боломжтой хүнтэй холбоотой бүх мэдээ, мэдээлэл юм. Жишээлбэл: таны нэр, утасны дугаар, хаяг, имэйл хаяг гэх мэт холбоо барих мэдээлэл, мөн таны өгсөн харилцагчийн төрсөн он сар өдөр гэх мэт (апп, вэб програм дахь) хувийн мэдээллийг оруулдаг. Та аппликейшн болон вэб аппликейшнд бусад хүмүүсийн хувийн мэдээллийг (жишээлбэл үйлчлүүлэгчид, гэр бүлийн гишүүд эсвэл ажлын хамтрагчид) оруулахдаа эдгээр хүмүүсийн мэдээллийн нууцыг хамгаалах бичиг баримттай танилцуулж, тэдний зөвшөөрөлтэйгөөр хувийн мэдээллийг нь оруулна уу.

Энэхүү хувийн мэдээлэл нь эцсийн байдлаар кодлогдох ба аппликейшн болон веб аппликейшн хариуцсан ажилтан харах эсвэл сэргээх боломжтой. Мэдээллийн нууцыг хадгалах мэдэгдлээрээ бид таны хувийн мэдээллийг хэрхэн цуглуулах, боловсруулах, энэ мэдээлэл нь юунд хэрэгтэй болон мэдээлэл цуглуулах, боловсруулахад эсэргүүцэх эрхтэй талаар мэдээлэх болно. Бид энэ мэдээллийн нууцыг хамгаалах мэдэгдэлдээ бид танд хувь хүний мэдээллийг хэрхэн боловсруулах тухай мэдээлэл өгнө.

Үүнд хадгалах, өөрчлөх, ашиглах, устгах гэх мэт зүйл орно. Энэхүү мэдээллийн нууцыг хадгалах мэдэгдэл нь эцсийнх биш. Зарим тодорхой үйлчилгээнд эсвэл бусад мэдээллийн нууц хадгалах бичиг, гэрээний заалт, оролцох нөхцөл эсвэл ижил төстэй бичиг баримтад ашиглана. Зарим үйлчилгээнд эсвэл өөр агуулгын хувьд өгөгдөл хамгаалах бусад тунхаглал, гэрээний заалт, оролцох нөхцөл, түүнтэй адилтгах баримт бичгийг ашиглаж болно.

2. Мэдээлэл боловсруулах ажлыг хэн хариуцдаг вэ?

ВАДЕМИКУМ-Дижитал, түүний мэдээллийн боловсруулалт хариуцагч

Dr. Ines Schlienger / Инес Шлингер
Segantinistrasse 155
CH-8049 Zürich
info@vademecum-digital.ch

Мэдээллийн хамгаалалттай холбоотой асуудлаар та дээрх хаягаар хандана уу.

3. Бид хувийн мэдээллийг яагаад цуглуулдаг вэ?

Бүх мэдээллийг боловсруулах нь тодорхой зорилгоор явагддаг. Эдгээр нь жишээлбэл, гэрээний шаардлага, хууль эрх зүйн зохицуулалт, техникийн шаардлага эсвэл таны шууд зөвшөөрөлтэй холбоотой байж болно. Бид үйлчилгээ үзүүлэх, захиалга, гэрээ боловсруулах, худалдах, нэхэмжлэх, асуулт, үйлчилгээ, бүтээгдэхүүн, түүнчлэн тэдгээрийн маркетинг, техникийн асуудал дахь дэмжлэг, бүтээгдэхүүн үйлчилгээний цаашдын хөгжил, үнэлгээнд шаардлагатай хувийн мэдээллийг цуглуулж боловсруулдаг.

4. Hosting / Хостинг

Энэхүү вэбсайтыг гадны үйлчилгээ үзүүлэгч эзэмшдэг (хостинг). Энэ вэбсайтад бүртгэгдсэн хувийн мэдээлэл нь хостын сервер дээр хадгалагддаг. Үүнд ялангуяа IP/бүртгэлийн хаяг, холбоо барих хүсэлт, харилцах мэдээлэл, гэрээний мэдээлэл, холбоо барих мэдээлэл, нэрс, вэбсайт руу нэвтрэх болон вэбсайтад бий болсон бусад мэдээлэл байх.

Эзэмшигч нь манай боломжит болон одоо байгаа үйлчлүүлэгчидтэй хийсэн гэрээгээ биелүүлэх, манай онлайн саналыг мэргэжлийн гүйцэтгэгчээр дамжуулан найдвартай, хурдан, үр дүнтэй хангах зорилгоор ашигладаг. Эзэмшигч нь гүйцэтгэх үүргээ биелүүлэхэд шаардлагатай тохиолдолд бидний зааврын дагуу таны мэдээллийг боловсруулах болно.

Вэбсайт эзэмшигч буюу үйлчилгээ үзүүлэгч (→ [DigitalOcean](#) = вэбсайтын линк) нь мэдээллийг цуглуулж вэбсайтад нэвтрэн „Сервер-Бүртгэлийн файлд“ хадгалдаг.

Дараах мэдээллүүд бүртгэгдэнэ.:

- Вэбсайтад зочилсон
- Хандалтын хугацаа
- Илгээгдсэн мэдээллийн хэмжээ
- Таны вэбсайтад нэвтэрсэн эх сурвалж
- Ашигласан хайлтын систем
- Ашигласан үйлдлийн систем
- Ашигласан IP-хаяг

Цуглуулсан мэдээллийг зөвхөн тоон үнэлгээ болон вэбсайтын сайжруулалтад ашиглана. Гэсэн ч вэбсайтын оператор нь хууль бус ашиглалтыг тодруулахаар тодорхой заалтын дагуу серверийн бүртгэлийн файлыг дахин шалгах эрхтэй.

5. ВАДЕМИКУМ-ын лиценз, материалыг борлуулах, түүнчлэн сургалт, мэдээлэл зэрэг холбогдох үйлчилгээг баталгаажуулах зорилгоор ямар хувийн мэдээллийг цуглуулдаг вэ?

Энэ нь манай вэбсайтыг ашиглахтай холбоотой мэдээлэл (ж.нь IP хаяг, ухаалаг утас эсвэл компьютерын МАС хаяг, төхөөрөмж болон таны тохиргоо, күүки, зочилсон огноо, цаг, ашигласан хуудас, агуулга, ашигласан функц, вэбсайт, байршлын тухай мэдээлэл), ВАДЕМИКУМ дижитал аппликейшн, вэб програм эсвэл манай мэдээллийн товхимлын тухай юм.

Хэрэв та өөрийн хувийн мэдээллийг тодорхой зорилгоор (жишээ нь манай холбоо барих хэлбэрүүдийн аль нэгийг нь ашиглан) боловсруулах зөвшөөрөл олгосон бол бид таны зөвшөөрлийг үндэслэн таны хувийн мэдээллийг боловсруулах болно.

Зөвшөөрлийг хүссэн үедээ цуцалж болно. Гэхдээ энэ нь аль хэдийн өгөгдсөн мэдээллийг боловсруулахад ямар ч нөлөө үзүүлэхгүй. Таны өгсөн мэдээлэл нь хүсэлтийг боловсруулж, дараагийн асуултыг шийдвэрлэх зорилгоор хадгалагдана. Таны хүсэлтийг шийдвэрлэсний дараа хувийн мэдээлэл автоматаар устгагдах болно. Жишээлбэл: манай мэдээллийн товхимлын төгсгөлд та захиалгаа цуцлах боломжтой холбоос байгаа.

6. Холбоо барих, И-мэйлээр хүсэлт илгээх, утас эсвэл захиа илгээх

Та манай веб сайтаас ВАДЕМИКУМ-лиценз, материал эсвэл сургалт, үйл ажиллагаанд оролцох хүсэлт илгээх веб-форм олох болно. Зайлшгүй оруулах шаардлагатай тодорхой заагдсан мэдээллүүд байгаа (холбогдох хэлбэрээр тэмдэглэгдсэн). Бид таны оруулах ёстой болон бусад сайн дурын байдлаар оруулсан мэдээллийг зөвхөн таны захиалгыг эсвэл бүртгэлийг хамгийн боломжит хувийн байдлаар боловсруулахын тулд ашиглана. Бид таны мэдээллийн нууцлалд анхаарлаа хандуулах ба мэдэгдэлтэй танилцаж ойлголттой болсныг баталгаажуулна. Вебсайтад оруулсан таны мэдээлэл вебсайт дахь мэдээлэл боловсруулагдсаны дараа устгагдах болно.

Хэрэв та холбоо барих маягтыг ашиглан бидэнд хүсэлт илгээвэл, маягтын мэдээлэл, таны өгсөн холбоо барих мэдээллийг багтаасан хүсэлтийг боловсруулж, холбогдох асуулт тавьсан тохиолдолд бид хадгална. Бид энэ мэдээллийг таны зөвшөөрөлгүйгээр дамжуулахгүй.

Хэрэв хүсэлт нь гэрээний гүйцэтгэлтэй холбоотой эсвэл гэрээний өмнөх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай бол бид таны мэдээллийг боловсруулна. Бусад бүх тохиолдолд боловсруулалт нь бидэнд илгээсэн лавлагааг үр дүнтэй боловсруулах хууль ёсны ашиг сонирхолд тулгуурласан эсвэл хүсэлт гаргасан тохиолдолд таны зөвшөөрлөөр үндэслэсэн болно. Таны холбоо барих маягтад оруулсан мэдээлэл хадгалагдах хүртэл (жишээ нь таны хүсэлт боловсруулагдсаны дараа) бидэнд байх ба та үүнийг устгахыг хүсэх эсвэл хадгалах зөвшөөрлийг тань цуцлахыг хүсвэл мэдээллийг хадгалах шаардлагагүй. Хууль тогтоомжийн заавал дагаж мөрдөх заалтууд, ялангуяа хадгалах хугацаа хэвээр байна.

7. ВАДЕМИКУМ-дигиталын хэрэглэхэд бид ямар мэдээллийг цуглуулах, боловсруулах вэ?

ВАДЕМИКУМ-дигитал нь нялх, балчир насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн хөтөч аппликейшнтэй веб програм юм. Ажиглалт хийж буй хүнд бүртгэл үүсгэхэд бүртгэл нээж буй мэргэжилтэнд хэрэглэгчийн нэр дээр нь бүртгэлтэй, хүчинтэй и-мэйл хаяг, ажиглалт хийх хүүхэд, насанд хүрэгчийн төрсөн огноо шаардлагатай. Тухайн хүний талаар дүгнэлт хийх нэмэлт мэдээлэл шаардлагагүй бөгөөд хадгалагдахгүй.

Лиценз авах, жил бүр сунгахын тулд админд хэрэглэгчийн хүчинтэй и-мэйл хаяг шаардлагатай. Веб програм болон аппликейшн нь ХБНГУ-д сервертэй. Мөн ажиглалт хийж буй хүний ажиглалт, түүний тайлбар мэргэжилтний тусламжтай хадгалагдана. Вэб програм нь бидний техникийн үзүүлэлтэд нийцүүлэн програмчлагдсан тул бидний үндсэн зорилгын дагуу шаардлагатай хувийн мэдээллийг агуулдаг.

Вэб програм, аппликейшнд хадгалагдаж буй цахим мэдээлэл нь бүгд эцсийн байдлаар кодлогдсон, нууц үгээр хамгаалагдсан байдаг тул гаднаас хэн ч хандах боломжгүй.

ВАДЕМИКУМ-ыг ашигладаг мэргэжилтнүүд бүгд хуулийн дагуу нууцлал хадгалах үүрэгтэй.

ВАДЕМИКУМ-апп болон веб програмын хэрэглэгчийн хувьд зөвшөөрлийг цуцлах бол аппликейшнд нэвтрэх эрх нээсэн хүнд хандана уу. Энэ нь холбогдох нэвтрэх эрх устгах үүрэгтэй.

Хэрэв та өөрийн бүртгэлтэй вэб програмын хэрэглэгчээс татгалзахыг хүсч байвал танд эрх нээсэн хүн эсвэл байгууллагад хандана уу.

S-Лицензийн хувьд ВАДЕМИКУМ-хариуцсан алба, M, L эсвэл XL-Лицензийн хувьд байгууллага хариуцсан байгууллагад хандана уу. Устгагдсан бүртгэлийг дахин сэргээх боломжгүй ба холбогдох бүх мэдээлэл дахин сэргээх боломжгүйгээр устгагдана. Мэдээж бид ВАДЕМИКУМ-дигитал хэрэгслийг улам сайжруулах, шаардлагатай хөгжүүлэлтийг хийх болно.

Үүний тулд бид гадны байгууллагатай хамтран ажилладаг. Цүрих дахь “triarc” компани нь бидэндтэй аппликейшн хөгжүүлэлт дээр ажилласан ба цаашид ч хамтран ажиллах болно. “triarc” компанийн хувьд АПП-хэрэглэгчийн и-мэйл хаяг, оруулсан мэдээллийг харах боломжтой.

ВАДЕМИКУМ-хариуцагч, Google болон triarc компаниудад ашиглалтын мэдээлэл шаардлагагүй. Цаашлаад бид ВАДЕМИКУМ-АПП-д хяналтын хэрэгсэл ашигладаггүй. Аппликейшны агуулга, техникийн сайжруулалтын талаарх мэдээлэл нь таны санал хүсэлт, лавлагаагаар дамждаг. VADEMECUM-хариуцагчид нэгдүгээр түвшний дэмжлэг үзүүлдэг. Хоёрдугаар түвшний дэмжлэгийг авахын тулд “tiarc” компанид шилжүүлнэ. Мэдээллийн нэрийг нууцалж “tiarc” компанитай аппликейшныг цааш хөгжүүлэхэд хамтран ажиллах шаардлагатай.

8. Манай вебсайт дахь күүки, нийгмийн сүлжээ, Веб-форм холбоосуудын тухай?

Бид вебсайтадаа “Cookies” гэж нэрлэгдэх жижиг текстэн мэдээллүүдийг оруулж өгсөн ба эдгээр нь таны компьютер болон хайлтын систем/хөтөч-д хадгалагддаг. Cookies нь манай вэбсайтыг илүү ээлтэй, илүү үр дүнтэй, аюулгүй болгохын тулд ашигладаг бөгөөд таны төхөөрөмжид ямар нэгэн хохирол учруулахгүй. Бидний дийлэнх хэрэглэдэг нь “Cookies”-г «Session-Cookies» гэж нэрлэдэг. Та манай вебсайтад зочилсны дараа автоматаар устгагдана. Бусад Cookies нь хадгалагдаж үлдэх ба устгагдахгүй.

Та дахин зочлоход таны хөтчийг танина. Ихэнх хөтөч Cookies-г хүлээн зөвшөөрөхөөр тохируулга хийгдсэн байдаг. Та өөрийн хөтчид Cookies-ын зөвхөн тодорхой тохиолдолд хүлээн зөвшөөрөх, зарим тохиолдолд Cookies-г хүлээн зөвшөөрөх эсвэл хөтчийг хаахад Cookies-г автоматаар устгах тохируулгыг хийж болно. Cookies-г идэвхгүй болговол манай вэбсайтын үйл ажиллагаа хязгаарлагдаж магадгүй юм.

Зарчмын хувьд Cookies нь мөн Google Analytics-ын вэб анализын үйлчилгээг ашиглахыг зөвшөөрдөг. Нийлүүлэгч нь Калифорния, Mountain View дахь Google Inc. Google Аналитик үйлчилгээний тусламжтайгаар манай вэбсайтын (хувийн бус) хэрэглээг хэмжих, үнэлэх боломжтой бөгөөд үүнийг бид ховор хийдэг. Манай үйлчилгээ үзүүлэгчийн тогтоосон байнгын Cookies мөн энэ зорилгоор ашиглагддаг. Та Google Analytics-г идэвхгүй болгосноор Google Analytics таны мэдээллийг цуглуулахаас урьдчилан сэргийлэх

боломжтой. Энэхүү Cookies-д тохирох тохиргоог хийсэн бөгөөд ингэснээр таны вэбсайтад дараагийн зочлох үед таны мэдээллийг хадгалахаас урьдчилан сэргийлнэ.

Google Analytics хэрэглэгчийн мэдээллийг хэрхэн зохицуулдаг талаар Google-ийн нууцлалын бодлогоос олж авах боломжтой.

<https://support.google.com/analytics/answer/6004245?hl=de>.

Google Analytics-ын таны мэдээллийг боловсруулах нь мэдээлэл хамгаалах журмын дагуу үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг юм.

(эндээс харна уу: <https://support.google.com/analytics/answer/6004245?hl=de>).

Google Analytics нь зөвхөн манай вэбсайтыг хэрхэн ашиглаж байгааг мэдээлдэг бөгөөд таны талаар ямар ч мэдээлэл өгдөггүй.

Google Аналитик нь бидний хувийн мэдээллийг хүлээн авахгүй (мөн IP хаяг хадгалдаггүй). Гэхдээ вебсайтын хэрэглээг дагах, мэдээллийг таны зочилсон бусад вебсайтын мэдээлэлтэй холбох, энэхүү мэдээллийг таны зочилсон бусад вэбсайтуудын мэдээлэлтэй нэгтгэх, мөн Google Analytics-ээс өөрийн зорилгод ашиглахыг хянах боломжтой (ж.нь зар сурталчилгааны хяналт). Хэрэв та өөрийгөө үйлчилгээ үзүүлэгч байгууллагад бүртгүүлсэн бол үйлчилгээ үзүүлэгч ч бас таны талаарх мэдээллийг мэдэж байна. Google Analytics таны мэдээллийг боловсруулах ба үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийг хамгаалах журмын дагуу хариуцна. (<https://support.google.com/analytics/answer/6004245?hl=de> үзнэ үү). Google Analytics нь зөвхөн манай вэбсайтыг хэрхэн ашиглаж байгааг хэлж өгдөг бөгөөд таны тухай хувийн мэдээлэл өгдөггүй.

Фэйсбүүк, твиттер гэх мэт нийгмийн сүлжээний холболтыг манай вэбсайтад ашигладаггүй. Бид Fox Computers (www.foxcomputers.ch) компанитай хамтран вэбсайтын цаашдын хөгжүүлэлтийн ажлыг хийхээр хамтран ажиллаж байна. Үүний тулд Fox Computers нь вэбсайтын мэдээлэлд заавал нэвтрэх шаардлагатай бөгөөд мэдээж үүнийг гадны зорилгоор ашиглахгүй. Манай вэбсайтыг холбоотой гадны вебсайтууд мэдээлэл хамгаалах журмыг дагаж мөрдөх хариуцлага хүлээхгүй.

9. Таны хувийн мэдээллийг хэр удаан хадгалах вэ?

Бид таны хувийн мэдээллийг гэрээний болон хууль ёсны үүргээ биелүүлэхэд эсвэл боловсруулж буй зорилгын дагуу шаардлагатай тохиолдолд боловсруулан хадгалдаг.

Жишээлбэл: ажил хэргийн харилцаа үргэлжлэх хугацаанд (гэрээг эхлүүлэх, боловсруулснаас гэрээг цуцлах хүртэл), түүнчлэн хууль тогтоомжийн дагуу хадгалах, баримтжуулах үүргийн дагуу боловсруулна. Хувийн мэдээлэл нь ВАДЕМИКУМ-ын эсрэг нэхэмжлэл гаргах хугацаанд хадгалагдах ба учир нь хуулийн дагуу үүрэг хүлээсэн эсвэл хууль ёсны хамтын ажиллагаа үүнийг шаарддаг (жишээ нь нотлох баримт, бичиг баримтын зорилгоор).

Таны хувийн мэдээлэл дээр дурдсан зорилгоор ашиглах шаардлагагүй болсон тохиолдолд техникийн хувьд устгах эсвэл нууцлах болно.

10. Мэдээллийн аюулгүй байдалд бид хэрхэн анхаардаг вэ?

ВАДЕМИКУМ-тай холбоотой таны хувийн мэдээллийг хэсэгчлэн болон бүрэн алдагдах, залилан, гуравдагч этгээд зөвшөөрөлгүй нэвтрэхээс хамгаалахын тулд бид зохих техникийн болон зохион байгуулалтын аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг ашигладаг. Бид одоогоор энэ чиглэлээр Fox Computers-тай нягт хамтран ажиллаж, аюулгүй байдлын

арга хэмжээг тасралтгүй хөгжүүлж байна. Энэ хуудас нь аюулгүй байдлын үүднээс болон нууц мэдээллийг дамжуулахад хамгаална. Жишээ нь: вебсайтын операторын илгээсэн лавлагаа, захиалга, SSL болон TLS код. Хөтчийн хаягийн мөр <http://auf> <https://> болж өөрчлөгдөх хөтчийн мөр дахь түгжих тэмдгээр шифрлэгдсэн холболтыг таньж болно. SSL болон TLS-түгжээ бүхий тэмдэг идэвхтэй байвал мэдээллийг бидэнд дамжуулах боломжтой ба гуравдагч этгээд унших боломжгүй. Мөн бид дотоод мэдээллийн хамгаалалтыг маш нухацтай авч үздэг. Манай ажилтнууд болон бидний томилсон гадны үйлчилгээ үзүүлэгчид нууцлал, мэдээлэл хамгаалах журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн. Бид таны мэдээллийг хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авдаг. Гэсэн хэдий ч интернет болон бусад цахим хэрэгслээр мэдээлэл дамжуулах нь аюулгүй байдлын тодорхой эрсдэлийг дагуулдаг бөгөөд ийм байдлаар дамжуулж буй мэдээллийн аюулгүй байдлыг бид баталгаажуулахгүй.

11. Хувийн мэдээллийг өгөх үүрэгтэй юу?

Бидний ажлын харилцааны хүрээнд харилцаа бий болгох, хэрэгжүүлэх, холбогдох гэрээ, хууль ёсны үүргээ биелүүлэхийн тулд эдгээр хувийн мэдээлэл шаардлагатай. Энэ мэдээлэлгүйгээр бид тантай (таныг төлөөлж буй албан газар эсвэл хүн) гэрээ байгуулах боломжгүй болно.

Лицензийг жил бүр сунгахын тулд худалдан авагчийн хүчинтэй и-мэйл хаяг болон шуудангийн хаягаас админд мэдэгдэх шаардлагатай. Хэрэв худалдан авагч тусгай зөвшөөрлийг сунгах боломжгүй бол нэвтрэх эрх хаагдах бөгөөд эрх жилийн дараа устгах болно.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим мэдээллийг (IP хаяг гэх мэт) задруулахгүйгээр манай вэбсайтыг ашиглах боломжгүй. ВАДЕМИКУМ аппликейшн, вэб програмыг ашиглахад имэйл хаяггүйгээр хязгаарлагдмал байдаг.

12. Таны хувийн мэдээлэлтэй холбоотой эрх?

Та мэдээлэл авах, залруулах, устгах, мэдээлэл боловсруулалтыг хязгаарлах эрхтэй бөгөөд мэдээллийг боловсруулж, хувийн мэдээллээ задруулахыг эсэргүүцэх эрхтэй. Мэдээллийг хамгаалах талаар нэмэлт асуулт байвал та дээрх хаягаар хүссэн үедээ холбоо барьж болно. Мөн эрх бүхий хяналтын байгууллагад гомдол гаргах эрхтэй.

13. Зохиогчийн эрх

Нийтлэгдсэн агуулга нь зохиогчийн эрх болон бусад хамгаалалтын хуулиар хамгаалагдсан бөгөөд тусгай зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор хуулж, тарааж, өөрчилж болохгүй. Энэ нь ялангуяа аппликейшн, холбогдох татан авалттай вэб програм, ICF-CY/Үйл ажиллагааны олон улсын ангилал-Хүүхэд залуучууд ангилалд хамаарна.

14. Нууцлалын бодлогын өөрчлөлт

Бид энэхүү мэдэгдлийг ямар ч үед (мэдээллийн нууцлалыг хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд) өөрчлөх, нэмэлт оруулах эрхтэй. Манай вэбсайт дээр тухай бүрт нийтлэгдэнэ. Хэрэв мэдээллийн нууцын бичиг баримт нь тантай хийсэн гэрээний нэг хэсэг бөгөөд шинэчлэгдсэн тохиолдолд өөрчлөлтийг танд и-мэйл эсвэл өөр тохиромжтой байдлаар мэдэгдэх болно.

Сүүлд шинэчлэгдсэн: 2020 оны 5-р сар